



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 564

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 49,700,000.00 (дөчин есөн сая долоон зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 32,923,194.41 (гучин хоёр сая есөн зуун хорин гурван мянга нэг зуун ерэн дөрвөн төгрөг дөчин нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Хөвсгөл авто замын засвар арчлалтын” төрийн өмчит хувьцаат компани, Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул, “Хөвсгөл авто замын засвар арчлалтын” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрах, Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал И.Жанболат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож санхүүгийн тайланд тусгах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001126

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 18 дугаар сарын 6-ны өдрийн
36-й дугаар тогтоолын хавсралт

"БАНУН БҮСҮЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Мицубиши L-200, 70-21 УБХ, MMBJRKVB407D027336	2008/2016	27,200,000.00	10,423,194.41	16,776,805.59	Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
2	Мицубиши L-200, 16-81 УБХ, MMBJNK74010015574	2001/2013	22,500,000.00	22,500,000.00	-	Хөвсгөл авто замын засвар арчлалтын төрийн өмчит хувьцаат компани
Нийт дүн			49,700,000.00	32,923,194.41	16,776,805.59	
			(нэг зуун гучинтаван сая таван зуун арван хоёр мянга дөрвөн зуун хорин)	(зургаан сая есөн зуун есөн мянга тавин долоон төгрөг наян хоёр мөнгө)	(нэг зуун хорин найман сая зургаан зуун гурван төгрөг гурван зуун жаран хоёр төгрөг арван найман мөнгө)	